

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Элка ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2025/043/НА-СТА-ОНӨҮГ**

Цахим хуудас: www.audit.mn	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Өмнөговь аймаг	Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
2025 он	Аудитын менежер: Т.Хонгорзул
	Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn
	Ахлах аудитор: Б.Алтанцэцэг
	Утас: 8000-7121 Цахим хаяг: tolinetugen@gmail.com
	Толин этүгэн аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Б.Отгон-Өлзий
	Утас: 99844655 Цахим хаяг: otgon1118@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.03.14 № 254
танай _____ -ны № _____ -т

ЭЛКА ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
С.НЯМДАВАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Элка ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС) -ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2,652,254.6 мянган төгрөгийн барилга байгууламж, 804,879.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 211,930.0 мянган төгрөгийн авто кран нийлүүлэгдэж бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллага тайлант онд 98,556.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн

4625020497

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Досх

тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамрахгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө	139,418,172.68	57,766,116.54
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	70,660,290.05	8,747,397.08
1.1.2	Дансны авлага	6,489,138.15	2,878,737.15
1.1.6	Бараа материал	59,944,303.21	41,225,859.07
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,324,441.27	4,914,123.24
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	139,418,172.68	57,766,116.54
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	2,847,515,351.96	6,368,123,916.35
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,824,089,435.38	6,345,301,333.10
1.2.2	Биет бус хөрөнгө	23,425,916.58	22,822,583.25
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,847,515,351.96	6,368,123,916.35
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,986,933,524.64	6,425,890,032.89
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр	2,629,179,306.09	6,166,691,992.90
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	18,619,451.53	2,725,477.00
2.1.1.3	Татварын өр	65,454.55	
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	18,553,996.98	2,725,477.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат өр төлбөр	2,610,559,854.56	6,163,966,515.90
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,610,559,854.56	6,163,966,515.90
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,629,179,306.09	6,166,691,992.90
2.3	Эздийн өмч	357,754,218.55	259,198,039.99
2.3.1	Өмч: - төрийн	290,724,837.86	290,724,837.86
2.3.5	- хувийн	22,498,000.00	22,498,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	66,614,994.46	66,614,994.46
2.3.9	Хуримтлагдсан (алдагдал)	(22,083,613.77)	(120,639,792.33)
2.3.11	Эздийн өмчийн дүн	357,754,218.55	259,198,039.99
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,986,933,524.64	6,425,890,032.89

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	304,184,850.55	408,242,064.66
2	Борлуулалтын өртөг	359,843,588.49	569,487,273.32
3	Нийт ашиг	(55,658,737.94)	(161,245,208.66)
4	Бусад орлого	125,043,925.65	227,310,795.54
5	Ерөнхий ба удирдлагын зардал	91,413,265.15	129,810,659.28
6	Бусад зардал		1,507,418.02
7	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	931,622.96	33,303,688.14
8	Бусад ашиг алдагдал	46,000.00	
9	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(22,913,700.40)	(98,556,178.56)
10	Орлогын татварын зардал		
11	Татварын дараах ашиг (алдагдал)	(22,913,700.40)	(98,556,178.56)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(22,913,700.40)	(98,556,178.56)
13	Бусад дэлгэрэнгүй орлого		-
14	Орлогын нийт дүн		
15	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	313,222,837.86	66,614,994.46	(22,083,613.77)	357,754,218.55
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	0.01	0.01
Залруулсан үлдэгдэл	313,222,837.86	66,614,994.46	(22,083,613.77)	357,754,218.55
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(98,556,178.56)	(98,556,178.56)
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	313,222,837.86	66,614,994.46	(120,639,792.33)	259,198,039.99

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	330,938,145.80	488,306,591.45
1.1.1	Бусад мөнгөн орлого	330,938,145.80	488,306,591.45
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	320,542,676.89	550,219,485.42
1.2.1	Ажиллагчдад төлсөн	126,136,806.00	238,703,661.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	41,360,151.22	67,930,954.74
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	48,010,054.23	58,084,553.66
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	28,739,029.17	33,885,242.02
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	31,344,420.00	59,225,920.00
1.2.6	Татварын байгууллагад төлсөн	39,083,256.27	60,039,304.00
1.2.7	Даатгалын төлбөрт төлсөн	5,868,960.00	32,349,850.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	10,395,468.91	(61,912,893.97)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	10,395,468.91	(61,912,893.97)
3	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	60,264,821.14	70,660,290.05
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	70,660,290.05	8,747,396.08

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Орлогын зүйл			
1.1	борлуулалтын орлого	357,993,474.00	370,907,511.00	(12,914,037.00)
1.2	Цэвэр бохир усны орлого	14,133,808.00	18,689,608.00	(4,555,800.00)
1.3	Шинээр үнэ тогтоосон хөрөнгийн орлого		3,470,000.00	(3,470,000.00)
1.4	Хогийн татаас	5,454,545.00	5,454,545.00	-
1.5	Хойшлогдсон орлого	152,489,530.00	191,236,141.00	(38,746,611.00)
1.6	зам үйлчилгээний татаас	13,190,400.00	13,190,400.00	-
1.7	Хог устгалын ажилтаны татаас	9,892,800.00	-	9,892,800.00
1.8	Нутгийн дэм		32,186,564.00	(32,186,564.00)
1.9	Ник 3% урамшуулал		418,090.88	(418,090.88)
1.10	Нийт борлуулалт	553,154,558.00	635,552,859.88	(82,398,301.88)
2	Зардлын зүйл			
2.1	Шатах тослох материал	26,256,657.00	15,249,321.00	11,007,336.00
2.2	Нүүрс /100тн/	-	-	-
	Тээврийн хөлс 2000тн	58,080,000.00	27,149,520.00	30,930,480.00
2.3	сэлбэг хэрэгсэл , ААМатериал	14,200,000.00	19,974,271.75	(5,774,271.75)
2.4	Хөдөлмөр хамгаалал	13,497,767.00	10,163,865.00	3,333,902.00
2.5	хог , ус, газрын төлбөр	440,000.00	440,000.00	-
2.6	үндсэн ба нэм цалин	296,917,300.00	266,389,021.00	30,528,279.00
2.7	НДШимтгэл	43,053,009.00	65,506,548.00	(22,453,539.00)
2.8	Ахмадын сан	8,907,519.00	8,464,062.00	443,457.00
2.9	түлш хөнгөлөлт	924,000.00	-	924,000.00
2.10	бичиг хэрэг зардал	712,236.00	1,132,672.00	(420,436.00)
2.11	Албан томилолт	700,000.00	420,000.00	280,000.00
2.12	үл хөдлөх хөр татвар	1,554,872.00	1,328,143.00	226,729.00
2.13	Үндсэн хөрөнгийн элэгдэл	53,242,310.00	52,039,606.00	1,202,704.00
2.14	Үндсэн хөрөнгийн элэгдэл /Хойшлогдсон орлогоор бүртгэгдсэн хөрөнгийн /	152,489,530.00	191,236,141.00	(38,746,611.00)
2.15	шуудан , холбоо	1,947,600.00	1,316,209.00	631,391.00
2.16	тх татвар , даатгал , үзлэг	662,700.00	201,273.00	461,427.00
2.17	Сургалт	7,650,000.00	1,580,000.00	6,070,000.00
2.18	Өндөр насны тэтгэвэрт гарах тэтгэмж	27,000,000.00	1,507,418.00	25,492,582.00
2.19	цахилгааны зардал	40,000,000.00	30,816,559.00	9,183,441.00
2.20	Шагнал урамшуулал , бусад	5,000,000.00	4,244,745.00	755,255.00
2.21	Банкны шимтгэл	150,000.00	127,200.00	22,800.00
2.22	Аудит төлбөр, Тусгай зөвшөөрөл сунгах	1,100,000.00	1,518,776.00	(418,776.00)
2.23	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз		33,303,688.00	(33,303,688.00)
	Нийт зардал	754,485,500.00	734,109,038.00	20,376,462.00
	Ашиг алдагдал	(201,330,942.00)	(98,556,178.00)	(102,774,764.00)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,500.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 1 зөвлөмж өгч ажилласан.

3.1 Зөвлөмж

Илрүүлэлт: 1

Мөнгөн кассаас хэнд, юунд, хэрхэн зарцуулсан нь тодорхойгүй, анхан шатны баримтгүйгээр 1,500.0 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил байна.

Өгсөн зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн 13.4.“Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”. 13.7.“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Өмнөговь аймгийн Элка ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй
тайлан

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн кассаас хэнд, юунд, хэрхэн зарцуулсан нь тодорхойгүй, анхан шатны баримтгүйгээр 1,500.0 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.4.“Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”. 13.7.“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалттай тус тус нийцээгүй байна.	1	1,500.0					1	1,500.0		
Нийт	1	1,500.0					1	1,500.0	-	-